



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

᠑᠗᠗᠗. ᠐᠑. ᠐᠑ № ᠙3᠖  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Х.ДАВААДОРЖ-Д

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч иргэн Хуягбаатар овогтой Даваадоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Хуягбаатар овогтой Даваадоржийн Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Х.Даваадоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Баянгол дүүргийн Сонгуулийн хороонд.

Хавсралт : : : хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



11 дүгээр хороо

/Мөрийн хөтөлбөр/



# “БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРООНД ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛНЭ”

Баянгол дүүргийн 11-р тойргийн нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч  
Хуягбаатар овогтой Даваадоржийн  
/мөрийн хөтөлбөр/

2023 он  
Улаанбаатар хот





## БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО

Улаанбаатар хотод Засаг захиргааны район байгуулах тухай БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1965 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотыг Найрамдал, Сүхбаатар, Октябрь, Ажилчин гэх 4 район болгон байгуулсан. Энэхүү АИХ-ын тогтоолоор тус хороо анх 1965 онд Октябрийн районы 18 дугаар хороо нэртэйгээр анх байгуулагдаж байсан.

Хорооны анхны даргаар Доной овогтой Дугаржав ажиллаж байв. Монгол улсын шинэ үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол Улсын Их Хурлаас 1992 онд “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль батлагдан засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц өөрчлөгдөн *Баянгол дүүргийн 11 дүгээр хороо нэртэй болсон.*

Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ, Хүн ам: 92 га, 6563 хүн ам, 1795 өрхтэй.

*Онцлог:* Эрүүлийг хамгаалах ЭХЭМҮТӨВ, Баянгол эмнэлэг, Гурван гал эмнэлэг, Вансэмбэрүү эмнэлэг, Гурван санчир өрхийн эрүүл мэндийн төв зэрэг байгууллагатай.

- Олон нийтийн хэвлэл мэдээллийн МҮОНРТ, UBS, SBN, Боролдой студи
- Хувийн хэвшлийн анхны дээд сургууль Сэрүүлэг дээд сургууль, Монголын үндэсний их сургууль, Радио телевизийн дээд сургууль, Хүрээ мэдээлэл технологийн дээд сургуультай.
- Ерөнхий боловсролын 28 дугаар сургууль, Сэтгэмж цогцолбор /46/ сургууль, Хүрээ тулга бүрэн дунд сургууль
- Сургуулийн өмнөх боловсролын 30, 57 дугаар цэцэрлэг, Энх өргөө хувийн цэцэрлэгтэй.
- Хорооны ААНБ: Нийт 98 аж ахуйн нэгж байгууллагатай.





11 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн зураг



1 cm = 2,70 km

| Таних тэмдэг |                       |
|--------------|-----------------------|
| ▲            | Цэцэрлэг              |
| ■            | Сургууль              |
| ■            | Эмнэлэг               |
| ■            | Дээд сургууль, коллеж |
| ■            | Хорооны цогцолбор     |
| МҮОНРТ       |                       |

Handwritten signatures and stamps in pink ink, including the text "1117145633" and "УХА0612 9077278".



## МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны айл өрх, иргэдийг эрүүл аюулгүй орчинд, амгалан тайван, аз жаргалтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд мөрийн хөтөлбөрийн зорилго оршино.

Үүнд:

1. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛТТАЙ БАЯНГОЛ

2. АМЬДРАХАД ТААТАЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

- Хоггүй гудамжтай айл, өрх
- Хөрсний бохирдолгүй айл, өрх
- Инженерийн шугамд холбогдсон айл, өрх

3. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ИРГЭНТЭЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

- Ногоон байгууламжтай айл, өрх
- Тоглоомын талбайг сайжруулах

4. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ИРГЭНТЭЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

5. АЮУЛГҮЙ АМГАЛАН БАЯНГОЛ ДҮҮРЭГ


2. Гэрэлтүүлэг, хяналтын камертай гудамж, талбай
3. Авто болон явган хүний замыг сайжруулах, шинээр бий болгох
4. Шинэчлэгдсэн хашаатай айл, өрх





## 1. Хоггүй гудамжтай айл өрх

Хог хаягдлын менежментийг шинэ түвшинд гаргаж "Хоггүй гудамж" төслийг хэрэгжүүлнэ. Айл өрх бүр ангилсан хогоо хаядаг хогийн савнуудыг бий болгож, ангилсан хогыг нь хоёрдогч түүхий эд авдаг компанитай хамтран хуванцар, шил, лаазнуудыг тушааж, өрхийн орлогод нэмэрлэж бусад хогийг нь хог хаягдал ачдаг Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ-тай хамтран 7 хоног бүр ачуулна.



## 2. Хөрсний бохирдолгүй айл, өрх


Баянгол дүүргийн 11 дүгээр хороо маань газар нутаг бага айл өрхийн төвлөрөл их, гэр хороолол учир олон жил нүхэн жорлон, угаадас асгадаг нүхнүүдийг ухаж түүнийгээ дүүрэхээр нь булж дахин өөр газар ухаж хийдэг учраас хөрсний бохирдол маш ихтэй. Ийм учраас нүхэн жорлонгуудыг байгаль экологид ээлтэй жорлонгоор солих ажлыг эхлүүлнэ.





### 3. Инженерийн шугамд холбогдсон айл, өрх

Хорооны айл өрхүүдийг цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, халаалтын төвлөрсөн болон бие даасан эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг төрийн болон хувийн компаниудтай хамтран хэрэгжүүлнэ. Мөн амины орон сууцтай айл өрхүүдтэй хамтран дулааны алдагдлыг багасгах бичил төслүүдийг хэрэгжүүлнэ.



### 4. Гэрэлтүүлэг, хяналтын камертай гудамж, талбай

Хорооны нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны болон гэр хорооллын гудамж талбайд шинээр гэрэлтүүлэг, камер суурилуулах ажлыг иргэд болон ААН, дүүрэгтэй хамтран хийнэ.







5. Авто болон явган хүний замыг сайжруулах,  
шинээр бий болгох

Орон сууц, гудамжны дундах эвдэрсэн авто зам, шороон замыг нөхөх, засварлах, шинэчлэх ажлыг нийслэл, дүүрэг, ААН, айл өрх болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.



6. Ногоон байгууламжтай айл, өрх

Хорооны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвх санаачлагд тулгуурлан айл өрхүүдийн хашаа дотор болон нийтийн эзэмшлийн зам талбайг зүлэгжүүлэх, мод тарих замаар ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

Ногоон орчин бүрдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ





## 7. Тоглоомын талбайг сайжруулах

Хүүхэд, залуучууд, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний эрүүл мэндийг дэмжих зорилгоор байгуулагдсан чийрэгжүүлэлтийн талбайд гүйлтийн болон дугуйн замуудыг тавиулах талаар дүүрэгтэй хамтран ажиллана.



## 8. Шинэчлэгдсэн хашаатай айл, өрх

Айл өрхийн хашаа хаалгыг нэгдсэн байдлаар шинэчилж, хашаа нь бетонон суурьтай, төмөр хүрээтэй, модон хашаа, төмөр хийцтэй гүйдэг хаалга болон явган хаалгатай болгоно. Ингэснээр иргэд өнгө үзэмжтэй гудамж талбайгаар зорчиж, оршин суугаа газартаа сэтгэл хангалуун, амар тайван, аз жаргалтай, баяр баясгалантай амьдрах боломжтой болно.



--ooOOOoo--

